



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/43

Бат-Өлзий сум

Ажил хүлээлцэх ажлын хэсэг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий тохижилт, үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын ажлыг хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)

О.Отгонтуяа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)

Б.Сангицэрэн (Нягтлан бодогч)

2. Бат-Өлзий тохижилт, үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын ажлыг 2024 оны 03 дугаар сарын 19-өөс 2024 оны 03 дугаар сарын 22-ны дотор акт үйлдэн хүлээлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА С.АМГАЛАН

